

БИЗНЕСИЙН САНААНААС ӨМЧИЙН ЭРХ - ОЮУНЫ ӨМЧИЙН ХАМГААЛАЛ, ХЭРЭГЖИЛТ

Хуульч Д. Уянга - хууль зүйн доктор, оюуны өмчийн зөвлөх үйлчилгээний салбарт бизнес эрхлэгч

Оюуны өмчийн эрх зүй нь хөрөнгө оруулалтын хамгаалах арга хэрэгслийг бий болгодог. Энэхүү илтгэлээр компьютерийн программ, интернэт агуулга, хувцас загвар, аялал жуулчлалын бизнест холбогдох зохиогчийн эрх, бүтээгдэхүүний загвар ба барааны тэмдгийн эрх зүйн хамгаалалтын тухай, холбогдох эрхүүдийг дотоодод ба гадаадад хэрхэн авах талаар танилцуулж ерөнхий ойлголт өгнө. Зарчмын хувьд зах зээлийн чөлөөт байдал, чөлөөт өрсөлдөөнийг эхний ээлжинд хангах ёстой дотоодын эрх зүйгээр оюуны өмчийг хуулийн хязгаарын дотор хамгаалдаг. Илтгэлээр оюуны өмчийн эрх үүсэх шалгуурын ерөнхий зураглалыг өгч, бизнесийн санаа ба оюуны өмчийн эрхийн ялгааг харуулна.

Оюуны өмчийн эрх үүсэх бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд бизнес эрхлэгчид оюуны өмчийн эрхийг аливаа гуравдагч этгээд зөрчсөн тохиолдолд дотоодод ба гадаадад хэнд хандаж, хэрхэн арга хэмжээ авах вэ? гэж асуудаг. Олон улсын нийтлэг жишиг энэ салбарт байдаг боловч Монгол Улсад энэ жишиг хараахан нэвтрээгүй. Илтгэлээр Монгол Улсад эрх хамгаалуулах арга зам ба гадаад улсад эрх хамгаалуулах нийтлэг жишгийг тайлбарлаж, ерөнхий дүр зураг, ойлголтыг өгнө.

FROM BUSINESS IDEAS TO PROPERTY RIGHTS – INTELLECTUAL PROPERTY PROTECTION AND ENFORCEMENT

Dr. Uyanga Delger, lawyer, advisor in International and Mongolian Intellectual Property Law

Intellectual property law provides for legal instruments that protect investment. This presentation will give an overview of copyright, industrial design, trademark law, covering protection of computer programs, internet content, designer clothes and tourism businesses by introducing the procedures for obtaining the rights both domestically and abroad. Intellectual property protection operates within the scope and limits of national law, which stipulate that free market and free competition rules have primacy. The presentation aims to give a general understanding of the requirements of intellectual property protection and the difference between business ideas and intellectual property rights.

In the case of goods and services protected by intellectual property law, business owners are interested in knowing to whom they may refer and which remedies are possible if their rights are infringed by a third party. There are common international practices and procedures in this regard. However, these practices and procedures are not familiar in Mongolia. The presentation will include the main features of intellectual property enforcement in Mongolia and abroad.